



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/449

Чойбалсан

Г

Цалинтай чөлөө олгох тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6, 32.1.7, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 14 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаан-Овоо, Хөлөнбуйр сумдад 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр байгалийн аюултай болон гамшигт үзэгдэл тохиож айл өрхийн гэр, хашаа хороо нурсан тул дээрх сумдад гэр бүл, аав, ээж, ах, эгч, дүү нь амьдардаг төрийн албан хаагчдыг гэр орноо сэргээн босгох, ар гэртээ туслах нөхцөл боломжоор хангаж, 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд 3 хоногийн цалинтай чөлөө олгохыг бүх сумын Засаг дарга, төрийн байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга, удирдлагуудад даалгасугай.

2.Тус шийдвэрийг хэрэгжүүлэх ажилд идэвх санаачилгатай ажиллахыг хувийн хэвшлийн байгууллагын удирдлагуудад уриалсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын орлогч дарга (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ

